

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2022 оны 11 дугаар сарын 14-ны өдрийн
2022/11 тоот тогтоолын 2-р хавсгалт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ЖУРАМ

Баримт бичгийн бүртгэл

Баримт бичгийн №	Хувилбарын огноо	Нэмэлт өөрчлөлт оруулсан тухай тайлбар тэмдэглэл	Төсөл боловсруулсан	Хянасан	Баталсан
	2013	Анхны хувилбар	"Гендекс"ҮЦК	ТУЗ	ТУЗ
	2022	"Компанийн засаглалын кодексыг шинэчлэн батлах тухай" СЗХ-ы 2022 оны №145 тогтоолын дагуу өөрчлөлт оруулсан	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Байгальмаа	Хуулийн мэргэжилтэн Д.Пүрэвцэрэн	ТУЗ

Агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Хорооны бүтэц, бүрэлдэхүүн
3. Хорооны хурал
4. Хорооны Бүрэн эрх
5. Хорооны үүрэг, хариуцлага
6. Ажлын тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо (“Хороо” гэх)-ны Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг баталж хянах, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах журмыг энэхүү журмаар зохицуулна.

2. Хорооны бүтэц, бүрэлдэхүүн

- 2.1. Хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Төлөөлөн удирдах зөвлөл нь Хорооны гишүүд болон даргыг томилно.
- 2.2. Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүд байх ба Хорооны гишүүн нь удирдан зохион байгуулах болон бусад холбогдох туршлагатай байна.
- 2.3. Цалин урамшууллын Хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
- 2.4. Компанийн Гүйцэтгэх захирал Цалин урамшууллын Хорооны гишүүн байхыг хориглоно.
- 2.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Цалин урамшууллын Хорооны нарийн бичгийн дарга байна.
- 2.6. Цалин урамшууллын Хорооны нарийн бичгийн дарга нь Хороог ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

3. Хорооны хурал

- 3.1. Хороо нь жилд 2 удаа хуралдана. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг Хорооноос жил бүр батална.
- 3.2. Хорооны дарга эсвэл хорооны аль нэг гишүүний хүсэлтээр хурлыг зарлан хуралдуулж болно.
- 3.3. Хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг Цалин урамшууллын Хорооноос жил бүр батална.
- 3.4. Хурлын зарыг ажлын 5 хоногийн өмнө тараах бөгөөд хуралд биеэр болон телеконференцийн хэлбэрээр оролцож болно.
- 3.5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд Хорооны даргын зөвшөөрснөөр хорооны хуралд оролцож болно.
- 3.6. Хорооны хурал нь 2 гишүүний ирцтэйгээр хүчин төгөлдөр болно.
- 3.7. Хурлаас гарах бүх шийдвэрийг олонхийн саналаар батална. Санал тэнцсэн тохиолдолд Хорооны дарга шийдвэрлэх санал өгнө.

4. Хорооны бүрэн эрх

- 4.1. Хороо нь дор дурьдсан асуудлаар дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулах, шийдвэр гаргана:

- 4.1.1. Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.1.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- 4.1.3. Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон Компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
- 4.1.4. Удирдах ажилтны цалин урамшууллын багцад гарах өөрчлөлтийг хянаж ТУЗ-д зөвлөмж хүргүүлэх;
- 4.1.5. Гүйцэтгэх удирдлагын аль нэг гишүүн болон компанийн ажиллагсдаас Хорооны нарийн бичгийн даргаар дамжуулан мэдээлэл шаардах.
- 4.1.6. Шаардлагатай тохиолдолд гадны хуулийн болон бусад хараат бус мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг авах.
- 4.1.7. ТУЗ-өөс үүрэг болгосон бусад асуудал.

5. Хорооны үүрэг хариуцлага

- 5.1. Хороо нь цалин, урамшууллын бодлогыг тодорхойлохдоо холбогдох дүрэм журмыг харгалзан дараах хүчин зүйлсийг анхаарна.Үүнд:
 - 5.1.1. ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагын мэргэжилтэн мэргэжлийн шаардлага хангахуйц ур чадвар, тогтвор суурьшилтай ажиллах эсэх тэдгээрийг идэвхжүүлэхэд хангалттай цалин, урамшууллын хэмжээг тогтоосон эсэх;
 - 5.1.2. Гүйцэтгэх удирдлагад ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан олгох урамшуулал нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх .Үүнд:
 - ✓ Бизнес төлөвлөгөөний хэрэгжилт
 - ✓ Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт
 - ✓ Инноваци
 - ✓ Үр ашиг
 - ✓ Өр зээл, авлагын барагдуулалт, авсан арга хэмжээ, үр дүн
 - ✓ Үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалт

6. Ажлын тайлан

- 6.1. Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын тэмдэглэлийг ТУЗ-ын бүх гишүүд болон гүйцэтгэх удирдлагад хүргэнэ. Тэмдэглэлд хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан чухал санал, дүгнэлтийг багтаасан байна.
- 6.2. Хороо нь албан үүргийнхээ хүрээнд хийсэн ажлаа жил бүр ТУЗ-д тайлагнана.